



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын “Илчит Хутаг” ОНӨХХК-ний 2024 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураагуй тайлан

**Аудитын код:** БУА-2025/008/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: [enhtsoodolj@audit.gov.mn](mailto:enhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: А.Сувдаа

Утас: 70342495

Цахим хаяг: [suvdaaa@audit.gov.mn](mailto:suvdaaa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.13 № 326

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

"ИЛЧИТ ХУТАГ" ОНӨХХК-ИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.АТАРСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Илчит Хутаг" ОНӨХХК-ий 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Жилийн эцсийн тооллогыг үнэн зөв хийгээгүй, өглөг, авлагын үлдэгдлийг тооцооны хуудсаар баталгаажуулээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 онд томилогдсон 7 гишүүнийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 15 дугаар тогтоолоор шинэчлэн томилжээ.

632502673

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, нярав нэгээс гурван удаа солигдсон байна.

### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
2	Эргэлтийн хөрөнгө		
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	54,203,572.58	10,008,177.06
4	Дансны авлага	36,100,370.00	20,368,605.19
8	Бараа материал	46,433,420.00	13,518,741.66
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		840,000.00
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	136,737,362.58	44,735,523.91
14	Эргэлтийн бус хөрөнгө		
15	Үндсэн хөрөнгө барилга	3,582,491,560.00	3,483,595,937.34
23	Биет бус хөрөнгө	3,212,000.08	6,799,833.43
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,585,703,560.08	3,490,395,770.77
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,722,440,922.66	3,535,131,294.68
29	Дансны өглөг		
30	Цалингийн өглөг	98,786.00	
31	Татварын өр	28,601,081.99	84,386,999.48
32	НДШ-ийн өглөг		2,317,171.68
38	Бусад богино хугацаат өр төлбөр	16,474,086.21	19,910,491.23
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	45,173,954.20	106,614,662.39
49	Өр төлбөрийн нийт дүн	45,173,954.20	106,614,662.39
50	Эздийн өмч		
51	Өмч: а) төрийн	4,405,291,861.00	4,405,291,861.00
56	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,378,191.00	20,378,191.00
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(748,403,083.54)	(997,153,419.71)
61	Эздийн өмчийн дүн	3,677,266,968.46	3,428,516,632.29
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,722,440,922.66	3,535,131,294.68

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/			
Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	720,735,136.11	804,810,937.18
2	Борлуулалтын өртөг	372,584,695.27	340,899,002.28
3	Нийт ашиг	348,150,440.84	463,911,934.90
8	Бусад орлого	145,134,090.89	83,573,636.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	587,114,950.42	773,082,106.99
12	Бусад зардал	39,417,491.39	14,021,590.44
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(133,247,910.08)	(239,618,126.17)
20	Татвар дараах ашиг (алдагдал)	(133,247,910.08)	(239,618,126.17)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(133,247,910.08)	(239,618,126.17)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,405,291,861.00			20,378,191.00			(615,155,173.46)	3,810,514,878.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-	-	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	(133,247,910.08)	(133,247,910.08)
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,405,291,861.00	-	-	20,378,191.00	-	-	(748,403,083.54)	3,677,266,968.46
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-	-	-	-	(239,618,126.17)	(239,618,126.17)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	(9,132,210.00)	(9,132,210.00)
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,405,291,861.00	-	-	20,378,191.00	-	-	(997,153,419.71)	3,428,516,632.29

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн (+)	958,661,398.12	891,128,320.30
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	865,639,577.92	803,898,128.54
8	Бусад мөнгөн орлого	93,021,820.20	87,230,191.76
9	Мөнгөн зарлагын дүн (-)	935,805,781.45	935,323,715.82
10	Ажиллагчдад төлсөн	213,964,212.00	271,386,230.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	63,384,014.81	84,652,642.16
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	370,082,072.25	260,225,943.48
13	Ашиглалтын зардалд төлсөн	83,822,644.47	125,192,026.00
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	40,727.27	65,497.27
16	Татварын байгууллагад төлсөн	79,176,363.05	82,262,136.66
18	Бусад мөнгөн зарлага	23,376,350.83	107,243,864.25
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	22,855,616.67	(44,195,395.52)
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	22,855,616.67	(44,195,395.52)
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,347,955.91	54,203,572.58
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,203,572.58	10,008,177.06

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэт - гэлийн хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>54,203,573</b>	(54,203,573)	
2	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>976,706,560</b>	<b>891,128,320</b>	85,578,240	91.2
2.1	Өөрийн орлого	<b>856,706,560</b>	<b>891,128,320</b>	(34,421,760)	104.0
	2.1.1 Дулаан үйлдвэрлэлийн орлого	675,090,560	803,898,129	(128,807,569)	119.1
	2.1.2 Туслах ажил, үйлчилгээний орлого	108,800,000			
	2.1.3 Шугам, сүлжээний цэвэр ус хангамжийн орлого	50,004,000	87,230,192	94,385,808	52.0
	2.1.4 Шугам, сүлжээний бохир ус татан, ариутгах орлого	22,812,000			
2.2	<b>Гаднаас авах санхүүжилтийн орлого</b>	<b>120,000,000</b>		120,000,000	-
	2.2.1 Гаднаас авах санхүүжилтийн орлого	120,000,000	-	120,000,000	-
3	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>972,626,726</b>	<b>935,323,716</b>	37,303,010	96.2
3.1	<b>Цалин, хөлс</b>	<b>375,473,550</b>	<b>271,386,230</b>	104,087,320	72.3
	3.1.1 Үндсэн цалин	375,473,550	271,386,230	104,087,320	72.3
3.2	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>49,904,194</b>	<b>84,652,642</b>	(34,748,448)	169.6
3.3	<b>Ашиглалтын зардал</b>	<b>107,740,000</b>	<b>111,466,433</b>	(3,726,433)	103.5
	3.3.1 Цахилгааны зардал	79,100,000	79,308,012	(208,012)	100.3
	3.3.2 Түлш, шатахууны зардал	28,640,000	32,158,421	(3,518,421)	112.3
3.4	<b>Түүхий эд, бараа материалын зардал</b>	<b>139,998,000</b>	<b>180,317,143</b>	(40,319,143)	128.8
	3.4.1 Сэлбэг хэрэгслийн зардал	24,600,000	40,644,521	(16,044,521)	165.2
	3.4.2 Нүүрсний зардал	92,000,000	107,116,283	(15,116,283)	116.4
	3.4.3 Бичиг хэргийн зардал	1,050,000	892,850	157,150	85.0
	3.4.4 Шуудан, холбоо, интернэтийн зардал	1,548,000	1,906,955	(358,955)	123.2
	3.4.5 Хангамжийн материалын зардал	13,120,000	22,076,534	(8,956,534)	168.3
	3.4.6 Хоолны зардал	7,680,000	7,680,000	-	100.0

3.5	<b>Хөдөлмөр хамгааллын зардал</b>		<b>19,332,000</b>	<b>4,352,000</b>	14,980,000	22.5
	3.5.1	Нормын хувцас	15,900,000	920,000	14,980,000	5.8
	3.5.2	Хордлого тайлах бүтээгдэхүүн	3,432,000	3,432,000	-	100.0
3.6	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>70,080,000</b>	<b>29,158,650</b>	40,921,350	41.6
	3.6.1	Урсгал засварын зардал	63,600,000	24,958,650	38,641,350	39.2
	3.6.2	Багаж, хэрэгсэл худалдан авах зардал	4,200,000	4,200,000	-	100.0
	3.6.3	Тавилга, эд хогшил худалдан авах зардал	2,280,000	-	2,280,000	-
3.7	<b>Томилолтын зардал</b>		<b>3,190,000</b>	<b>1,583,066</b>	1,606,934	49.6
	3.7.1	Дотоод албан томилолтын зардал	3,190,000	1,583,066	1,606,934	49.6
3.8	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал</b>		<b>192,190,000</b>	<b>248,039,552</b>	(55,849,552)	129.1
	3.8.1	Нүүрс тээврийн зардал	145,800,000	165,777,415	(19,977,415)	113.7
	3.8.2	Сургалтын зардал	2,010,000		2,010,000	-
	3.8.3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	41,940,000	82,262,137	(40,322,137)	196.1
3.9	<b>Нийгмийн хамгаалал</b>		<b>14,718,982</b>	<b>4,368,000</b>	10,350,982	29.7
	3.9.1	Дотоод журмын дагуу олгох тэтгэмж, тусламж	5,068,982	1,848,000	3,220,982	36.5
	3.9.2	Шилдэг ажилчдын урамшуулал	5,400,000	2,520,000	2,880,000	46.7
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>4,079,834</b>	<b>10,008,177</b>	(5,928,343)	245.3
5	<b>Нийт ажиллагсад</b>		<b>27</b>	<b>27</b>	-	100.0
	5.1	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	5.2	Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100.0
	5.3	Үйлчлэх ажилтан	7	7	-	100.0

## Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Илчит хутаг ОНӨХХК нь иргэд, байгууллага, аж ахуй нэгжид стандартын шаардлага хангасан цэвэр ус түгээх, бохир усыг татан төвлөрүүлэх, бохир усыг татан төвлөрүүлж ариутган цэвэрлэх, дулаан нийлүүлэх, хог хаягдлыг ачиж зайлуулах, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээг зохиох гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Илчит хутаг ОНӨХХК-ий дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэл, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах,
- Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ,
- Ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ,
- Цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ,
- Бохир усны гаргалгааны цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ,
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ,
- Хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээ,
- Халуун ус, саун, хувцас угаалгын үйлчилгээ,
- Барилгын гадна, дотно засал, орчны тохижилтын үйлчилгээ,
- Нийтийн эзэмшлийн зам талбай, суваг шуудуун засвар ашиглалт,
- Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн засвар ашиглалт,
- Хог хаягдалд ангилан ялгах, татан зайлуулж, дарж булшлах, хоёрдогч түүхий эд бэлтгэн нийлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Нийтийн эзэмшлийн цэцэрлэгжүүлэлт, ойжуулалт, ногоон байгууламжийн тохижилт, засвар үйлчилгээг эрхлэн явуулж байна

## Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 178,248.5 мянган төгрөгийн орлогын 12 гүйлгээ, зарлагын 60,791.2 мянган төгрөгийн 11 гүйлгээг бүрэн мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.2.10-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### **Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулсан эсэх, эдийн засгийн төлөвлөгөө баталсан тогтоолыг хэрэгжилтийг хянах үзэх.

### **Зургаа. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 23,550.7 мянган төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснээс 22,061.3 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж залруулагдаагүй 1,489.4 мянган төгрөгийн 1 алдаанд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Ээлжийн амралтын 9,654.9 мянган төгрөгийг 5 болон 6 дугаар сард дутуу бүртгэж тайлагнасан нь УСНББОУС-1,2 тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Цалин дутуу бүртгэснээс ажил олгогчийн НДШ-ийн зардал, өглөгийг дутуу бүртгэсэн нь УСНББОУС-1,2 тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Элэгдлийн зардлыг цалингийн зардал руу 49.8, ашиглаж буй багаж хэрэгслийн зардал дансанд 1,177.5 мянган төгрөгөөр зардлын ангилал андуурч бүртгэл хөтөлсөн нь УСНББОУС-17, оршин байх батламж мэдэгдэл,
- Өмнөх онд ААНОАТ өглөг 7,826.0, ажилчдад тэтгэмжид 1,078.0, 228.2 мянган төгрөгийг тус тус шилжүүлэхдээ зардал болон холбогдох өглөгийг хүлээн зөвшөөрч бүртгэл хөтөлж тайлагнаагүйгээс хасах өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь УСНББОУС-1,2 тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Урьдчилж төлсөн авлагыг шууд зардлаар бүртгэсэн нь УСНББОУС-1, 2, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 57,128.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 57,128.0 мянган төгрөгийн 5 албан шаардлагыг өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 58,617.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 44,151.6 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

## 6.2 Албан шаардлага

1. Тайлант онд 4,382.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 15.6.6 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж хэвших

2. Тайлант онд 2,311.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 15.6.6 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

3. Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны Б/55 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс 12 дугаар сарын 10-ны өдрөөс 16-ны өдрийн хооронд гүйцэтгэсэн ч тооллогыг үнэн зөв, чанартай гүйцэтгээгүй, тооллого хийж дууссанаас хойш 12 дугаар сарын 17-31-ний хооронд бараа материал нийт 17,310.0 мянган төгрөгийн орлого, 27,851.2 төгрөгийн зарлагын хөдөлгөөн хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4, 73.2 дахь заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, *нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг* хангахгүй

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, журмын дагуу тайлагнах

4. Жилийн эцсийн тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүйгээс үндсэн хөрөнгө 5,272.6 мянган төгрөгөөр дутуу тоолсон, тооллогод үнэт цаасны үлдэгдлийг хамруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4, 73.2 дахь заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, *нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг* хангахгүй

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, журмын дагуу тайлагнах

## 6.3 Зөвлөмж

1. Мөнгөн гүйлгээний тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Арилжааны банкны хуулгаарх орлого, зарлагын дүнгээс мөнгөн гүйлгээний тайланд орлого 634.7 мянган төгрөг, зарлага 854.7 мянган төгрөгөөр илүү хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.6, 14.4.5, 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.3-д заасны дагуу тайлагнах.

## 2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Эхний хагас жилийн тайланг санхүүгийн программаар тайлагнаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** НББ-ийн тухай хуулийн 9-д заасны дагуу хагас жилийн тайланг холбогдох санхүүгийн программаар тайлагнаж ТТЗ-д нэгтгүүлэх.

### Долоо. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
“Илчит Хутаг” ОНӨХХК	6	23,525.2	2	10,836.3	4	12,688.9	5	22,061.3	1	1,489.4	1	1,489.4
Дүн	6	23,525.2	2	10,836.3	4	12,688.9	5	22,061.3	1	1,489.4	1	1,489.4

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
“Илчит Хутаг” ОНӨХХК	5	57,127.9	0	0	4	57,127.9	1	-	0	0	0	0
Дүн	5	57,127.9	0	0	4	57,127.9	1	-	0	0	0	0

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
“Илчит Хутаг” ОНӨХХК	1	239,039.7	0	-	1	239,039.7	0	-
Дүн	1	239,039.7	0	0	1	239,039.7	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
“Илчит Хутаг” ОНӨХХК	1	-					1	-
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Нийт дүн	2	239,039.7	0	0	1	239,039.7	1	0

#### Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		